



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024. 07. 19 № 593

танай 2024. 07. 17 ны № 05 -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд 7
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Дорнод аймгийн Хэрлэн сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хэрлэн сумын Монгол ардын намын Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн

хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хэрлэн сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр (таван хуудас)-ыг хавсаргав.

Хувийг: “Хэрлэн сумын Монгол ардын намын хороо”-нд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 5 хуудастай.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС
2024 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 9 ДЭХ УДААГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хэрлэн сум 1-р баг

1. Нисэхийн замыг гэрэлтэй болгох ажлыг эхлүүлэх.
2. Залуус хорооллын урд хэсэг буюу Улаан худаг орчмын айлуудад инженерийн шугам сүлжээний оруулга гаргах ажлыг эхлүүлэх.
3. Хуучин төв хогийн цэгийг бүрэн дарж булах.
4. Бунханы 50 дугаар байранд бохирын байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.
5. Бунханы 50 дугаар байранд гадна пассад хийх.
6. Гудамжны гэрэлтүүлгийн ажлыг үргэлжлүүлэх.
7. Силикат хорооллын дулааны шугам хоолойг хойш үргэлжлүүлэх ажлыг хэрэгжүүлэх.
8. Төв зам дагуу айл өрхийн /нүүрний/ эгнээг янзалж нэг хэлбэрийн болгож хашаажуулах.
9. Багийн гэр хорооллын дундуур камержуулах ажлыг хийх.
10. 327 дугаар ангийн хойно хурд сааруулагч хийх.
11. Үндны усны худаг гаргах ажлыг хийх.
12. Бунханы задгай талбайн хогийг цэвэрлэх ажлыг хийх.
13. Гэр хорооллын айл өрхүүдийн хогийг хашааны гаднаас авдаг хогийн савтай болгох ажлыг эхлүүлэх.
14. Ялалт гүүрийг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх.




Хэрлэн сум 2-р баг

1. 2 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг эхлүүлэх.
2. Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж байгуулах. /Модон гүүрний хажууд голын эрэг дээр/
3. Хэрлэн, Март, Чойбалсан, Тээвэрчид гудамжинд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх.
4. Багийн ажлын албаны байр шинээр барих. \багийн иргэдийн дунд\
5. Бага сургуулийн уурын зуухны засварын ажлыг хийж дуусгах.
6. Төмс хүнсний ногоо, мод тариалах өрхүүдэд гүний худагтай болоход дэмжлэг үзүүлэн ажиллах.
7. Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэдэд жимсний модны суулгац олгох.
8. 2 дугаар цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг тохижуулах.
9. Гэр хорооллын эгнээ хоорондын шороон замыг сайжруулан засварлах.
10. Орон сууцны байрны гадна тохижилтийг үе шаттай хийх.
11. Хотын гэрлэн чимэглэлийг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх.
12. Нийтийн эзэмшлийн талбай дахь тоглоомын талбайг үе шаттай засварлаж сайжруулах.
13. Тоглоомын талбай байгуулах орчны тохижилт хийх
14. 3x3 сагсны талбай байгуулах.
15. Модон гүүрийг шинэчлэн бетонон гүүр болгох ажлыг эрчимжүүлэх.



Хэрлэн сүм 3-р баг

1. Хүүхдийн парк байгуулах ажлыг үргэлжлүүлэн хийх
2. Танк, Түргэн, Бат-Уул, Овоот хэсгийн айл өрхийн дундуур гэрэлтүүлэг тавих.
3. Багийн нутаг дэвсгэрт камержуулалтыг нэмэгдүүлэх.
4. Нийтийн байруудад ОО, муу усны нүх, хогийн сав цогцоор нь шийдэх.
5. Багт баригдаж байгаа бага сургуулийн барилгын ажлыг эрчимжүүлэх.
6. Багийн ажлын албаны байранд их засвар хийх.
7. Овоот хэсгийн хойд талаар цахилгааны шугам тавих.
8. Түргэн хэсэгт цэвэр усны шугам тавих.
9. Дэнж хэсэгт ундны усны худаг гаргах.
10. Ногоон гүүр, Түргэн, Бумбат хэсэгт тоглоомын талбай байгуулах.



Хэрлэн сүм 4-р баг

1. Гэр хорооллын хог хаягдлын менежментыг сайжруулан хоггүй баг төсөл хэрэгжүүлэх.
2. Гэр хорооллын гудамж төсөл үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
3. Хийморийн овоо төслийг үргэлжлүүлэн, авто зам зогсоол бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах.
4. Хан-Уул, Зангигат эгнээнд дулааны шугамаас айл өрхүүдийг дулааны шугамд холбогдох дэд бүтцийн ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.
5. Цахилгааны дэд станц болон шугам шугам сүлжээний өргөтгөлийн ажлуудыг үе шатаар хэрэгжүүлэн өвлүүн улиралд айл өрхүүдийг цахилгаан дулааны асуудлаа шийдэх нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллах.
6. Авто болон явган замын засвар шинэчлэлийн ажлуудыг хийж хэрэгжүүлнэ.
7. Сургууль, цэцэрлэг, гэр хорооллын эгнээ гудамжнуудад гэрэлтүүлэг болон хяналтын камерын систем сууринуулан аюулгүй орчин бүрдүүлнэ.
8. Усан сангийн байршлын цэгийг оновчтой төлөвлөн Дорнод нийтийн аж ахуй ОНӨААТҮГ-тай хамтран ухаалаг худгийн тоог нэмэгдүүлнэ.
9. Гэр хорооллын дахин төлөвлөлт хийлгэж, орон сууцны хороолол хотхон барих төсөл хэрэгжүүлнэ.
10. Орон сууцны байрны гадна фасадыг шинэчилж, нэг өнгийн стандартад оруулна.
11. Хүүхдийн тоглоомын талбай орон сууцны дунд байгуулна.
12. Босоо чиглэлийн авто замын усны хоолойг засварлан шинэчлэх

Хэрлэн сүм 5-р баг

1. Өгөөмөрийн айлууд руу тог татах ажлыг зохион байгуулах.
2. Хүүхдийн тоглоомын талбай болон ахмад настнуудад зориулсан чийрэгжүүлэлтийн талбайтай болгох.
3. Хүнсний ногоо тариалдаг өрхийг хүлэмж төсөлд хамруулах.
4. Ялалт гүүрний урд замын ажлыг үргэлжлүүлэх.



Хэрлэн сум 6-р баг

1. Уурхайн байрны зүүн талаар авто зам тавих. Урд төв зам, хойд төв замыг холбосон хөндлөн чиглэл.
2. Уурхайн байрны зүүн талд ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах.
3. Буйр хорооллыг төвийн цэвэр бохирын шугаманд холбож, залуус хороолол шиг хаус хороолол болгох ажлыг дахин төлөвлөлтөнд тусгуулж эхлүүлэх.
4. Ивээл хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг үргэлжлүүлэх.
5. Чита гудамжийг гэрэлт гудамж болгон тохижуулах.
6. Хог хаягдлын менежментийг сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь төсөл хэрэгжүүлэх.
7. Өнөр хорооллын 20, 21 дүгээр байранд ус зайлцуулах хоолой хийх
8. Уурхайн байрны гадна пасадыг шинэчлэх ажлыг эхлүүлэх.
9. Ивээл хорооллын дахин төлөвлөлтөд ороогүй хэсгийн байруудад шугам хоолой, дээвэр, цахилгаан монтажын шинэчлэл хийх ажлыг эхлүүлэх.
- 10.Хэрлэн сумын 17 дугаар цэцэрлэгт хүүхэд хөгжлийн бие бялдарын танхим тохижуулах.
- 11.Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгт иж бүрэн засвар хийх ажлыг эхлүүлэх.
- 12.Хэрлэн сумын 5 дугаар сургуулийн шугам хоолойг шинэчлэх, иж бүрэн засвар оруулах ажлыг эхлүүлэх.
- 13.Хэрлэн сумын Шинэ хөгжил цогцолбор сургуулийн дэргэдэх 500 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих ажлыг эхлүүлэх.
- 14.Хүүхдийн тоглоомын талбай байгуулах. /багийн хэмжээнд 10 байршилд цогц тоглоомын талбай/
- 15.Багийн нутаг дэвсгэрт ноогдох Хэрлэн голын эрэг, далангийн тохижилт хийх.
- 16.Зүүн бүсийн худалдааны төв Шүр захын авто замыг шинэчлэх, орчны тохижилтын ажлыг эхлүүлэх.
- 17.Уурхай, Үүрийнтуяа хотхонуудыг төв завтай холбосон авто зам тавих.
- 18.Ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийг эрчимжүүлэх


Хэрлэн сум 7-р баг

1. 29-39 дүгээр орон сууцны байрны гадна фасадыг шинэчлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.
2. “Найрамдал 2” цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлэх.
3. Багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх.
4. Орон сууцны гадна талд зөөврийн хогийн савтай болох.
5. Хиймэл нуурыг тохижуулж иргэн аж ахуй нэгжтэй гэрээлэн хариуцуулах ажлыг эхлүүлэх.
6. Наймдугаар сургуулийн бага сургуулийг цэцэрлэг болгох ажлыг хэрэгжүүлэх.
7. Мянгатын арын замыг үргэлжлүүлэн дуусгах.
8. Иргэдийн чөлөөт цагийн танхим байгуулах
9. Авто машины замыг өргөтгөх, зогсоолыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.
- 10.Мянган жаргалан өрхийн эмнэлгийн байрны өргөтгөл хийх
- 11.Тусгаар тогтолцоо талбайн тохижилтын ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.
- 12.Хүүхдийн тоглоомын талбайг насны ангиллаар төрөлжүүлэн үргэлжлүүлэн шинэчлэн сайжруулах
- 13.Багийн нутаг дэвсгэрийг бүрэн камеражуулах.



Хэрлэн сум 8-р баг

1. 56,57,58 дугаар байрны гадна фасадыг шинэчлэх ажлыг эхлүүлэх
2. Баяннуурын эрэг орчмын тохижилтын ажлыг эхлүүлэх. /Чөлөөт цагийг өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулах/
3. Гэр хорооллын айл өрх рүү дэд бүтэц татах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.
4. Гэр хорооллын эгнээ гудамжийг “Жишиг гудамж” болгон тохижуулах
5. Орон сууцны байруудын гадна талбайд Спортын талбай шинээр хийх. /Сагс, волейбол/
6. Залуус хорооллоос Баянтумэн өртөө хүртлэх авто замыг асфальтан зам болгох ажлыг эхлүүлэх. /явган хүний зам, дугуйн зам/
7. Багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, иж бүрэн камержуулах ажлыг зохион байгуулах.
8. 56.57.58 дугаар байруудын орцны засвар үйлчилгээ, автомашины зогсоол



Хэрлэн сум 9 дүгээр баг

1. Хог боловсруулах үйлдвэр байгуулах.
2. Ахмадын ордонтой болох ажлыг эхлүүлэх.
3. Орон сууцны гадна ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, иргэдэд таатай тохижилтын ажил үе шаттай хийх.
4. 1-17 дугаар байрны гадаах фасад дулаалга бүрэн хийх
5. Орон сууцны гадна машины зогсоолыг бүрэн шийдэж камержуулах ажлыг үе шаттай хийх.
6. Найрамдал паркийг бүрэн тохижуулж сүүдрэвч, сандал нэмэгдүүлэх, боловсон бие засах газрыг байгуулна.
7. Орон сууцуудын дундах авто замын тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлж зарим замыг нэг чиглэлийн урсгалтай болгож, хурд сааруулагч тавих ажлыг хийнэ.


Хэрлэн сум 10-р баг

1. Ялалт хороололд хүүхдийн цэцэрлэг барих ажлыг эрчимжүүлэх.
2. Орон сууцны байрны цэвэр бохир усны шугамыг хэсэгчлэн солих.
3. Гэр хорооллын эгнээ хоорондын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.
4. Эгнээ бүрт үе шаттайгаар цэвэр дулааны шугамтай болох ажлыг хэрэгжүүлэх.
5. Инженерын шугам сүлжээний трассын зураг гаргаж, газар чөлөөлөх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.
6. Гэр хорооллын эгнээ хоорондын замыг сайжруулсан шороон зам болгон засварлах.
7. Цахилгаан эрчим хүчний дэд станц шинээр барих өргөтгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.



Хэрлэн сум 11-р баг

1. Ахмадын чөлөөт цагийн танхимтай болох
2. Уурхайчин хорооллын нуурыг цэцэрлэгт хүрээлэн болгон тохижуулах.
3. Багийн нутаг дэвсгэрийн хүрээнд шөнийн дуу хураагууртай камертай болох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.
4. Шинээр ахуй үйлчилгээний төв барих ажлыг хэрэгжүүлэх.
5. Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг өнгөрөөх танхим байгуулна.
6. Гэр хорооллын гэрэлтүүлгийг бүрэн дуусгана.
7. Талын шилтгээний зүүн талын замыг сайжруулсан шороон замтай болгоно.
8. Долоодой сургуулийн уулзварт гэрлэн дохио хийнэ.



---000---

